

2025оны
Тэжон Бугон дээд сургуулийн
Солонгос хэлний хөтөлбөрт элсүүлэх
заавар

Гадаад харилцааны алба



1. Гадаад харилцааны алба(Солонгос хэлний хөтөлбөр)-ны танилцуулга

Тэжон Бугон дээд сургуулийн гадаад харилцааны алба(Солонгос хэлний хөтөлбөр) нь гадаад улсад бүрэн дунд болон түүнээс дээш боловсрол эзэмшсэн гадаад иргэд болон Солонгост оршин суугаа гадаад иргэдэд, солонгос хэлний түвшингийнх нь дагуу ангиудад хуваагдан явагдах хөтөлбөр юм. Бид оюутнуудад солонгос хэлний мэдлэгийг системтэйгээр зааж, түвшинг нь ахиулж, цаашлаад их дээд сургуульд элсэн суралцах болон Солонгост өөрийн мөрөөдлөө биелүүлэхэд нь туслан, солонгос хэлний өндөр ур чанартай боловсролыг олгох болно.

2. Солонгос хэлний хөтөлбөр(Тогтмол явагдах сургалт)

Тэжон Бугон дээд сургуулийн Солонгос хэлний ээлжит хөтөлбөрийн үндсэн гол зорилго нь солонгос хэлний сургалтаар дамжуулан гадаад оюутнуудын солонгос хэлний харилцааны ур чадварыг дээшлүүлэх юм. Энэ нь ярих, сонсох, унших, бичих зэргээс бүрдэнэ.

3. Солонгос хэлний хөтөлбөрийн үйл явц

Семестер	10 долоо хоног	Нийт цаг	200цаг(Даваа ~ Баасан) Өдөрт 4цаг
Төлбөр	Семистер тутамд 1,000,000вон (Сурах бичиг ороогүй)	Анги тус бүрийн хүний тоо	20 хүнээс доош
Хичээллэх цаг	Өглөөний анги 09:00 ~ 13:00		
Нээгдэх анги	Солонгос хэлний 1-р түвшин ~ 6-р түвшин хүртэл, түвшин тогтоох шалгалтаар анги хуваана(солонгос хэл огт мэдэхгүй хүмүүсийг 1-р түвшинд оруулна) 2025 оны 9 сарын намрын семистерт анхан шатны анги нээхээр төлөвлөж байна.		
Төгсөх шалгуур	Дүн 70 онооноос их, ирц 80%-с их биш бол төгсөлтийн шалгуурыг хангаагүй гэж үзэн төгсөх боломжгүй болно(сургалтанд суух хугацаа нь хамгийн дээд тал нь 2 жил)		
Бусад	Галын аюулгүй байдал туршилт, тусгай лекц, оюутны зөвлөл гэх мэт		

4. Солонгос хэлний хөтөлбөрт элсэхэд тавигдах шаардлага

- Ахлах анги төгссөн юмуу түүнтэй адилтгах боловсролтой хүн.
- Солонгос хэлний бэлтгэлд элсэх виз(D-4-1 гэх мэт)-ний эрхээ хасуулаагүй хүн.

5. Солонгос хэлний хөтөлбөрт элсэх хуваарь

Семистер	Хугацаа (20 долоо хоног)	Бүртгэл дуусах	Тэнцсэн хүмүүсийг зарлах	Бүртгэл
Намар	25/9/8~11/14	~07/12хүртэл	Материал хүлээн авснаас хойш долоо хоногийн дотор	Тэнцсэн хүмүүст мэдэгдсэний дараа шууд
Өвөл	12/04~02/09	~09/05хүртэл		

※ Дээрх хуваарь нь сургуулийн нөхцөл байдлаас хамааран өөрчлөгдөж болно.

6. Солонгос хэлний хөтөлбөрийн сонгон шалгаруулалт хийгдэх арга

▶ Сонгон шалгаруулалтын хүчин зүйл болон харьцаа

Сонгон шалгаруулалтын арга	Харьцаа	Агуулга
Бичиг баримтын сонгон шалгаруулалт	100% (100оноо)	Өргөдөл гаргагчийн ирүүлсэн хэлний мэдлэг, хичээлийн дүн, бусад баримт бичгийг нийтэд нь үнэлнэ. ※ Шаардлагатай тохиолдолд ярилцлага(биечлэн юмуу интернет)-ээр хийж, үнэлгээнд оруулна.

▶ Сонгон шалгаруулалтын шаардлага

1. Сонгон шалгаруулалтыг нийт онооны дарааллын дагуу шалгаруулна. Гэвч, шаардлагатай элсэлтийн шалгалтын оноог хангаагүй гэж үзсэн тохиолдолд сонгон шалгаруулахгүй болно.
2. Адил оноотой тохиолдолд: Бүгдийг нь тэнцсэнд тооцно.
3. Бүрдүүлсэн бичиг баримт бүрэн бус юмуу худал мэдээлэл агуулсан өргөдлийг хүчингүйд тооцно.

▶ Сонгон шалгаруулалт болон элсэлтийн журам

① Элсэлтийн бүртгэл болон бичиг баримт өгөх. - Шуудангаар болон биечлэн ирж өгөх.	»	② Бүртгэлийн шалгуур болон бичиг баримтын сонгон шалгаруулалт ※ Хэрэгтэй гэж үзвэл ярилцланд орно. (Биечлэн болон видео ZOOM ашиглан)	»	③ Тэнцсэн хүмүүсийг зарлана. ④ Төлбөрөө төлнө. ⑤ Элсэлтийн гэрчилгээ(COA) олгоно.	»	⑥ Виз мэдүүлнэ ⑦ Хичээл эхлэнэ(Оюутны үнэмлэх баталгаажуулах болон хичээлийн бүртгэл хийгдэнэ)
---	---	---	---	--	---	--

※Хятад, Вьетнам, Монгол, Узбекистан улсууд виз олгох гэрчилгээ гарсны дараа виз мэдүүлнэ.

7. Солонгол хэлний хөтөлбөрийн үйл ажиллагааны гарын авлага(Хичээлийн хуваарь)

Хичээлийн цаг өдөрт 4цаг, долоо хоногт 5 удаа(Даваа~Баасан) хичээллэнэ.

Нэг анги 20 орчим сурагчтай, элссэн оюутны тоо болон түвшин тогтоох шалгалтын үр дүнг үндэслэн ангид хуваана.

※ Анги бүрдэлт үүсэхгүй бол тухайн анги нээгдэхгүй байж болно.

Хичээлийн сэдвүүд: Үгсийн сан болон үндсэн хэрэглээний яриа, дүрэм, ярих, сонсох, унших,

бичих гэх мэт.

►Тусгай хөтөлбөр

- Шинэ элчэгчдийн нээлтийн өдөрлөг
 - Соёлын хөтөлбөр: Солонгосын уламжлалт соёлыг үзэж, мэдрэх
 - Үдээс хойш орох тусгай анги: Тусгай анги, Солонгос хэлний түвшин тогтоох шалгалт(ТОPIK)-т бэлтгэх анги гэх мэт.
 - Солонгос хэлний дадлага болон гадаадад суралцах талаарх зөвлөгөө
- ※ Тусгай хөтөлбөр нь семистер бүрийн үйл ажиллагааны нөхцөл байдлаас шалтгаалан өөрчлөгдөж болно.

►Багш

•Багш: Солонгос хэлний багш гэрчилгээтэй, багшлах арвин туршлагатай, маш сайн ур чадвартай багш нараас бүрдсэн болно.

8. Солонгос хэлний хөтөлбөрт бүрдүүлэх материал

■ Солонгос хэлний хөтөлбөрт бүрдүүлэх материал

Ангилал	Бүрдүүлэх материал
1. Хувийн бичиг баримт	[1-1] Элсэлтийн өргөдөл(Хувийн мэдээллийг ашиглахыг зөвшөөрсөн бичгийн хамт)
	[1-2] Өөрийн танилцуулга(Гадаадад суралцах төлөвлөгөө – Солонгос хэл дээр)
	[1-3] Гадаад пастортны хуулбар
	[1-4] Өнгөт зураг 3ш(3.5cm×4.5cm/сүүлийн бсарын дотор авахуулсан, цагаан дэвсгэртэй байх)
	Гадаадад оршин суугаа хүмүүст зориулсан нэмэлт бичиг баримт [1-5] (Солонгос элчин сайдын яамнаас(Консулын газраас) заасан эмнэлээс, сүрьеэгийн шинжилгээний хариуны хуулбар(цээжний рентген зураг орно)
2. Иргэншил нотлох бичиг баримт	[2-1] Эцэг эхийн иргэний үнэмлэх(эсвэл паспорт)-ны хуулбар. Англи хэл дээр биш бол англиар орчуулан баталгуужуулах.
	[2-2] Төрөл садангийн лавлагаа(Хятад: өрхийн бүртгэлийн дэвтэр)-ны хуулбар. Англи хэл дээр биш бол англиар орчуулан баталгуужуулах.
3. Боловсролт ой холбоотой бичиг баримт	[3-1] Бүрэн дунд боловсролын гэрчилгээ(боловсролын гэрчилгээ батлах), эх хувиар [3-2] Бүрэн дунд боловсролын дүн (Англи биш бол орчуулан баталгаажуулах)-гийн хуулбар ** Боловсролын гэрчилгээ батлах: Доорх ①, ②, ③-аас сонгоно уу(Гэхдээ, БНХАУ-ын сургууль бол ③ л байхад болно) ① Апостиль(Apostille) баталгаа авсан зэрэг(боловсрол) гэх мэт нотлон бичиг баримт ② Төгссөн сургууль нь харьяалагддаг Солонгосын консулын газар эсвэл Солонгосын ЭСЯ-ны консулын газраас баталгаажуулсан(боловсрол) нотлох бичиг баримт

	<p>③ Хэрэв та БНХАУ-д эрдмийн зэрэг хамгаалсан бол Хятадын Боловсролын яаманд харьяалагддаг “Боловсрол, эрдмийн зэргийн гэрчилгээ олгох төв”-өөс гаргасан боловсролын гэрчилгээний тайлан өгөх.</p> <p>Харин, боловсролын гэрчилгээ гардаггүй Хятадын мэргэжлийн сургуулийг төгссөн тохиолдолд,</p> <ul style="list-style-type: none"> - Аймгийн боловсролын газраас(эсвэл хотын боловсролын хэлтсээс) олгосон төгсөлийн гэрчилгээ(БНХАУ дахь Солонгосын консулын газраас баталгаажуулсан байх шаардлагатай) - Сургуулиас олгосон төгсөлтийн гэрчилгээ [Аймгийн боловсролын газар(эсвэл хотын боловсролын хэлтэс) болон БНХАУ дахь Солонгосын консулын газраас баталгаажуулсан байх ёстой] <p>※ БНХАУ-ын ХНХЯ(Хөдөлмөр нийгэм хамгааллын яам)-ны харьяа мэргэлийн дунд сургуулиудын хувьд, “Хүний нөөц, нийгмийн асуудал эрхэлсэн яамны гэрчилгээ” болон “БНХАУ-д суугаа Солонгосын консулын газар”-аас баталжуулсан байх шаардлагатай.</p>
4. Санхүүгийн чадварын баталгаа	<p>[4-1] Өргөдөл гаргагч эсвэл санхүүгийн батлан даагчийн банкны хадгаламжийн үлдэгдлийн гэрчилгээний хуулбар(англи хэл дээр биш тохиолдолд орчуулан баталгаажуулах) - Банкны үлдэгдэл: USD 10,000 ам.доллар ба түүнээс дээш</p> <p>※ Виз мэдүүлсэн өдрөөс өмнөх, 30 хоногийн доторх банкны үлдэгдлийн гэрчилгээ хүчинтэй(Гэхдээ, банкны үлдэгдлийн гэрчилгээ нь хугацаатай тохиолдолд бсар хүртэл зөвшөөрөгдөнө.)</p> <p>Гадаадад оршин суугчдад зориулсан нэмэлт бичиг баримт</p> <p>[4-2] Өргөдөл гаргагч эсвэл санхүүгийн батлан даагчийн ажлын газрын тодорхойлолт болон ажлын туршлагын гэрчилгээ(хаана ажиллаж байсан)-ний хуулбар</p> <p>※ Компаний нэр, ажилласан хугацаа, зэрэг гэм мэт</p> <p>[4-3] Өргөдөл гаргагч эсвэл санхүүгийн батлан даагчийн орлогын гэрчилгээний хуулбар(цалин болон жилийн орлого) англи хэл дээр биш бол орчуулан баталгаажуулах</p> <p>** Санхүүгийн батлан даагч: Зөвхөн өргөдөл гаргагчийн эцэг эх батлан даах боломжтой.(ах дүү, хамаатан садан санхүүгийн батлан даагч болох боломжгүй)</p> <p>※ Вьетнам хэлний оюутнуудад зориулсан санхүүгийн баталгааны тусгай шаардлага</p> <ul style="list-style-type: none"> - Баталгаажуулах арга: Гадаад суралцах зардлыг батлах тогтолцоо(Төлбөрийн арга нь банкны бүтээгдэхүүнд бүртгүүлсэн бол гадаадад суралцах зардлын барьцааны гэрчилгээ ирүүлэх)

9. Сургалтын төлбөр/Дотуур байр/Бусад зардал

■ Дотуур байр: Зэрэг олгох хөтөлбөрийн гадаад оюутнуудыг хувиарлан, үлдсэн өрөөг зохих ёсоор хуваарилна.

Дотуур байранд орохыг сонговол сургалтын төлбөрт оруулна: (6,500~8,200сар/өдөр)

■ Нэмэлт зардал –

Өргөдлийн хураамж 20,000вон(Сургалтын төлбөрт багтаан, нэхэмжлэл гаргана)

Даатгалын хураамж 70,000вон(Сургалтын төлбөрт багтаан, нэхэмжлэл гаргана)

- Хилээр орж ирсний дараах оюулгүй байдлын даатгал(Улсын эрүүл мэндийн даатгалд бүртгүүлэхээс 3сарын дотор)

*Гадаад иргэний үнэмлэх авах хураамж, сурах бичгийн хураамж болон бусад банкны данс нээх хураамж гэх мэтийг хилээр нэвтэрч орж ирсний дараа төлнө.

Гадаад иргэний үнэмлэхний хураамж 35,000вон, Банкны данс нээх хураамж 1,000вон, бусад бичиг баримтны гэрчилгээ авах төлбөр 1,000вон, сурах бичгийн хураамж гэх мэт.

등록금납부정보 은행명: 하나은행 입금주명: 대전보건대학교-국제교류원 계좌번호: 646-910095-08105 swift code: KOEXKRSE
--

Банкны	нэр:	Ханабанк(Hanabank)
Хүлээн авагчийн нэр: 대전보건대학교-국제교류원		
Дансны дугаар: 646-910095-08105		
swift code: KOEXKRSE		

10. Гадаад оюутнуудыг улсын эрүүл мэндийн даатгалд заавал бүртгүүлэх заавар

Улсын эрүүл мэндийн даатгалын тухай хууль болон 「Хуулийг хэрэгжүүлэх журам」 -ын дагуу 2021оны 3 сараас эхлэн улсын эрүүл мэндийн даатгалд, орон нутгийн захиалагч автоматаар, заавал бүртгүүлэх ёстой.

※ Дэлгэрэнгүй мэдээллийг бүртгүүлсэн хүмүүст удирдамжаар мэдэгдэх болно.

11. Бусад

* Өргөдөл гаргах хугацаанд бүх бичиг баримтыг явуулах

(Материалын хуулбар: pdf)-ийг international@hit.ac.kr хаягруу ирүүлнэ үү.

-> 1-р шат: Бичиг баримтыг шалгах

-> 2-р шат: Онлайн ярилцлага

-> Эцсийн шатанд тэнцсэний дараа бүх бичиг баримтыг (эх хувь)-р нь явуулах.

11. Холбоо барих

Тэжон Бугон дээд сургуулийн Гадаад харилцааны албаны хуудас: <https://www.hit.ac.kr/global>

Хаяг: 대전광역시 동구 충정로 21 (가양동, 대전보건대학)

Утасны дугаар: +82-42-670-9038

Факс: +82-42-670-9561(입학처)

E-mail: international@hit.ac.kr